

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА**  
**ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Гүйцэтгэлийн аудитын алба



**ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН**

---

**УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ  
ХОЛБОГДСОН УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫН  
ТӨЛӨВЛӨЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН  
ТАЙЛАН**

**АУДИТЫН КОД:УАГ-ХОА/2020/-ГА-02**

---

Ховд хот  
2020 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын захирал бөгөөд  
Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар  
Утас: 99047408 Цахим хаяг: Boldbaatar.khu@audit.gov.mn  
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн  
Утас:99013699 Цахим хаяг:tsetsegsuren.a@audit.gov.mn  
Ахлах аудитор: Д.Мөнхтулга  
Утас:7043-2545 Цахим хаяг: : munkhtulga.d@audit.gov.mn  
Аудитор: Б.Должинжав  
Утас:7043-2545 Цахим хаяг:doljinjav.b@audit.gov.mn

---

---

<p><b>Аудитыг гүйцэтгэж тайланг бэлтгэсэн:</b></p>	<p><b>Товчилсон үгийн жагсаалт ..... Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй стандартын талаарх мэдэгдэл</b></p>	<p>4</p>
<p><b>ҮАГ-ын харьяа Ховд аймаг дахь аудитын газар</b> Тэргүүлэх аудитор Х.Болдбаатар Утас Аудитын менежер А.Цэцэгсүрэн Утас 99013699 Ахлах аудитор Д.Мөнхтулга Утас:99031809 Аудитор Б.Должинжав Утас: 99305432 <b>2020 оны 08 дугаар сар</b></p>	<p><b>Бүлэг 1. Улсын төсвөөс олгох санхүүжилтийг хэрэгцээний дагуу төлөвлөн СЕХ-оос ирүүлсэн аргачлалын дагуу хуваарилсан ч урамшуулалт цалингийн НДШ-ын зардал, улсын бүртгэлийн газарт төлөвлөн олгосон зарим зардал оновчтой төлөвлөгдөөгүй байна.</b></p> <p>1.1 Аймгийн сонгуулийн хороонд улсын төсвөөс 479.1 сая төгрөгийг хуваарилжээ. 5</p> <p>1.2 Аймгийн сонгуулийн хороо нь хэсгийн хороодод олгох төсвийг СЕХ-ноос ирүүлсэн аргачлалын дагуу хуваарилсан байна. 5</p> <p>1.3 Улсын бүртгэлийн Ерөнхий газраас сонгуулийн зарим зардлыг бодитой төлөвлөж хуваариллаагүй байна. 6</p> <p>1.4 Аймгийн ОБГ-т 68.1 сая төгрөгийн бараа материалыг төлөвлөсөний дагуу хувиарласан байна. 6</p>	<p>5 5 6 6</p>
<p><b>Уг тайланг ҮАГ-ын Веб сайтаас үзнэ үү. <a href="http://www.audit.gov.mn">www.audit.gov.mn</a></b></p>	<p><b>Бүлэг 2. Сонгуулийн хууль, холбогдох журмыг мөрдөн ажиллаж байгаа ч зарим төсвийг үр ашиг, арвилан хэмнэлттэйгээр зарцуулаагүй байна.</b></p>	<p>7</p>
<p>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70432545 дугаарын утас, 70433061 дугаарын факсаар харилцана уу.</p>	<p>2.1 Сумдын сонгуулийн хороо нь батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулжээ 7</p> <p>2.2 Аймгийн сонгуулийн хороо нь 5.3 сая төгрөгийг үр ашиггүй зарцуулжээ. 7</p> <p>2.3 Аймгийн сонгуулийн хороо нь сумдын сонгуулийн хорооны тайланд нийт 3.1 сая төгрөгийн алдааг залруулсан нэгтгэсэн байна. 8</p> <p>2.4 Улсын бүртгэлийн хэлтэс сонгуулийн зардлыг холбогдох хууль, журмыг мөрдөж зарцуулсан ч зарим зардлыг үр ашиг, арвилан хэмнэлттэй зарцуулаагүй, санхүүгийн дотоод хяналт хангалтгүй байна 9</p> <p>2.5 Онцгой байдлын газар хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналт, анхан шатны баримтын бүрдлийг сайжруулах шаардлагатай байна. 9</p> <p>2.6 Засгийн газрын нөөц хөрөнгөөс санхүүжүүлсэн зардлыг зориулалтын дагуу зарцуулсан эсэхийг нотлох санхүүгийн баримт хангалттай түвшинд бүрдээгүй байна. 9</p> <p>2.7 Аймгийн сонгуулийн хороо нь сумдын сонгуулийн хороодын хөрөнгийн зарцуулалтад хяналт тавин ажилласан ч бараа материалын зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах шаардлагатай. 10</p>	<p>7 7 8 9 9 9 10</p>
<p><b>ХАЯГ:</b> Ховд аймгийн Засаг даргын Тамгын газар Ховд аймаг дахь Төрийн Аудитын газар 3 давхар</p>	<p>Аудитын зөвлөмж ..... Тэргүүлэх Аудиторын тушаал ..... Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал: .....</p>	<p>11 12 13</p>

## Товчилсон үгийн жагсаалт

<b>АДБОУС</b>	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
<b>УИХ</b>	Улсын их хурал
<b>ЗГ</b>	Засгийн газар
<b>ҮАГ</b>	Үндэсний Аудитын газар
<b>ИТХ</b>	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
<b>СЕХ</b>	Сонгуулийн ерөнхий хороо
<b>УБХ</b>	Улсын бүртгэлийн хэлтэс
<b>ОБГ</b>	Онцгой байдлын газар

**1.1.Аудит хийх бүрэн эрх, үндэслэл:** Аудитыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2019 оны аудитын сэдэв батлах тухай 04 дүгээр тогтоол, Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/53 дугаар тушаалаар баталсан Үндэсний Аудитын газрын 2020 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу Ховд аймаг Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

**1.2 Аудитын зорилт:** УИХ-ын 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулан Аймгийн ИТХ, Засаг дарга, холбогдох байгууллагуудад танилцуулж, иргэд, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ. .

Аудитын зорилтыг ханган биелүүлэхийн тулд дараах чиглэлээр аудит хийнэ.

- УИХ-ын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журам, зориулалтын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх
- УИХ-ын сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх

**1.3 Аудитын хамрах хүрээ:** Аудитад Аймаг, сумдын сонгуулийн хороо, УБХ, ОБГ байгууллагуудыг хамрууллаа. Аймгийн Цагдаагийн газарт улсын төсвөөс олгосон санхүүгийн анхан шатны баримтыг Цагдаагийн Ерөнхий газарт хүргүүлсэнтэй холбогдуулан хамруулсангүй.

**1.4 Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт:** Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, АДБОУС 400, АДБОУС 3000, АДБОУС 4000 дугаар стандартууд, Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журмыг баримтлан Аймаг, сумдын сонгуулийн хорооны холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, судалгаа авч шинжилгээ хийх, санхүүгийн тайлан, анхан шатны баримт, ажлын төлөвлөгөө, тайлантай тулган баталгаажуулах арга зүйг ашиглан аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох бусад мэдээллийг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитад Төсвийн тухай хууль, Татварын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сонгуулийн тухай хууль, Сонгуулийн ерөнхий хорооноос гаргасан эрх зүйн актууд

**Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн:** Аудитыг газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар удирдан, аудитын менежер А.Цэцэгсүрэн аудитын арга зүйгээр хангаж, үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Д.Мөнхтулга аудитор Б.Должинжав нар гүйцэтгэв.

**Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл:** Аудитын тайлангийн I Сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журам, зориулалтын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх II Сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх талаар тайлагнаж ерөнхий зүйл, аудитын дүн, аудитын дүгнэлт, зөвлөмж, холбогдох газрын санал гэсэн агуулгаар бичлээ.

**Бүлэг 1: Улсын төсвөөс олгох санхүүжилтийг хэрэгцээний дагуу төлөвлөн СЕХ-оос ирүүлсэн аргачлалын дагуу хуваарилсан ч урамшуулалт цалингийн НДШ-ын зардал, улсын бүртгэлийн газарт төлөвлөн олгосон зарим зардал оновчтой төлөвлөгдөөгүй байна.**

**Аймгийн сонгуулийн хороонд улсын төсвөөс 479.1 сая төгрөгийг хуваарилжээ.**

1.1 Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийг 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр батлан, 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсөн байна. Ховд аймгийн Сонгуулийн хороог СЕХ-ны 2020 оны 4 дүгээр сарын 14-ны өдрийн 20 тоот тогтоолоор 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулжээ. Аймгийн сонгуулийн хороо нь 17 сумдын сонгуулийн хороог 2020 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн 02 тоот тогтоолоор 87 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулжээ. Харьяалагдах нутаг дэвсгэрийн хэмжээнд 17 сумын 91 хэсгийн хороотойгоор нийт 879 төрийн албан хаагч ажиллаж СЕХ-оос 479.1 сая төгрөгийн санхүүжилтийг авсан байна.


1.2 УИХ-ын 16-р тойрогт нийт 54343 сонгогч бүртгэгдсэнээс 43116 сонгогч саналаа өгч 79.4 хувийн ирцтэй оролцжээ. СЕХ-ны 2020 оны 22 дугаар тогтоолоор баталсан “Хяналтын тооллого хийх журам”-ын дагуу 91 хэсгээс 33 хэсэг буюу 36.3 хувьд санамсаргүй сонголтын аргаар хяналтын тооллогыг зохион байгуулсан байна.

1.3 Аймгийн сонгуулийн хороо нь УИХ-ын ээлжит сонгуулийг зохион байгуулах, сумдын сонгуулийн хороог байгуулах, арга зүйгээр хангах чиг үүрэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулжээ.

**Аймгийн сонгуулийн хороо нь хэсгийн хороодод олгох төсвийг СЕХ-ноос ирүүлсэн аргачлалын дагуу хуваарилсан байна.**

1.4 УИХ-ын ээлжит сонгууль зохион байгуулахтай холбоотойгоор СЕХ-оос аймгийн Сонгуулийн хороонд 479.1 сая төгрөгийн санхүүжилтийг хуваарилж гүйцэтгэлээр 478.9 сая төгрөгийн зардал санхүүжүүлж 0.3 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийг төсөвт төвлөрүүлжээ.

1.5 Сонгууль зохион байгуулахтай холбоотой зардлыг сумдын сонгуулийн хороонд хуваарилахдаа хүн амын тоо, газар нутгийн хэмжээг үндэслэжээ. Аймгийн сонгуулийн хороо нь СЕХ-оос ирүүлсэн зөвлөмжийн дагуу холбогдох зардлуудыг сумдын сонгуулийн хороонд хуваарилан ажиллажээ. Аймгийн сонгуулийн хороо нь нийт төсвийн 11.9 хувь буюу 56.9 сая, сумдын сонгуулийн хороодод 88.1 хувь буюу 422.2 сая төгрөгийг хуваарилжээ.



1.6 2016 оны УИХ-ын сонгуулиас сонгуулийн насны хүн амын тоо 2925, санал өгсөн хүний тоо 1513-аар тус тус нэмэгджээ. 2016 онд Буянт суманд 6 хэсгийн хороо ажилласан бол 2020 оны сонгуулиар 5 болж хэсгийн хорооны тоо 1-ээр буурсан байна. Бусад сумдын хэсгийн хорооны тоонд өөрчлөлт ороогүй байна.

**Улсын бүртгэлийн Ерөнхий газраас сонгуулийн зарим зардлыг бодитой төлөвлөж хуваарилаагүй байна.**

1.7 Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны хүрээнд Улсын бүртгэлийн Ерөнхий газрын даргын 2020 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн А/595 дугаар тушаалаар Ховд аймагт сонгууль зохион байгуулах зардалд 92009.5 мянган төгрөгийг баталж, хуваарилснаас сонгууль зохион байгуулах үйл ажиллагаанд 85785,0 мянган төгрөгийг зарцуулж, төрийн сангийн харилцах дансанд 6224,5 мянган төгрөг зарцуулагдаагүй үлджээ.

Зардлын нэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Тайлбар
Мөнгөн урамшуулал	55,560,0	55,560,0	-	Хэтэрсэн
Сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэх бичиг хэргийн зардал	6,340,5	4,035,0	(2,305,5)	Хэмнэсэн
Сургалт зохион байгуулах зардал	19,731,0	14,897,0	(4,834,0)	Хэмнэсэн
Техник хэрэгсэл тээвэрлэх болон шуурхай багийн зардал	10,378,0	11,293,0	( 915,0)	Хэтэрсэн
<b>ДҮН</b>	<b>92,009,5</b>	<b>85,785,0</b>	<b>(6,224,5)</b>	<b>Хэмнэсэн</b>

Улсын бүртгэлийн байгууллагын ажилтан, итгэмжлэгдсэн ажилтны болон гэрээт ажилтны мөнгөн урамшуулал, хоол унааны зардалд 55.6 сая, сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэхэд шаардагдах бичиг хэргийн зардалд 6.3 сая, сургалт зохион байгуулах болон түүнтэй холбогдон гарах бусад зардалд 19.7 сая, сонгогчийг бүртгэх, таних техник хэрэгслийг тээвэрлэх болон техник хэрэгслийн хэвийн ажиллагааг хангаж ажиллах шуурхай багийн зардалд 10.4 сая нийт 92,0 сая төгрөгийн төсвийг тооцоо судалгаанд үндэслэн баталж хуваарилсан ч төлөвлөлтөд дараах зөрчил дутагдал илэрлээ.

- Мөнгөн урамшууллын нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг төсөвт тусгаж батлаагүйгээс суутган тооцож тайлагнаагүй,
- Сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэх бичиг хэргийн зардалд 6.3 сая төгрөгийн зардал баталсан боловч үүнээс 5.5 сая төгрөгийн зардлыг үндэслэлгүй төлөвлөсөн,

**Аймгийн ОБГ-т 68.1 сая төгрөгийн бараа материалыг төлөвлөсөний дагуу хувиарласан байна.**

Засгийн газрын 2020 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн 199 дүгээр тогтоолын дагуу Онцгой байдлын ерөнхий газраас аймгийн Онцгой байдлын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд 3.3 сая төгрөгийг Улсын Их Хурлын сонгуулийн санал хураах байранд томилогдон ажиллах алба хаагчдын томилолтын зардалд зарцуулахаар, Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх журмын хэрэгжилтийг хангах зорилгоор сонгогчид болон, сонгуулийн ажилтны тоогоор 7 нэр төрлийн 121474 тоо ширхэг бүхий 68,1 сая төгрөгийн амны хаалт, бээлий, гар ариутгагч, хлорын шохой зэрэг бараа материалыг хуваарилсан байна.

Аймгийн хэмжээнд нийтдээ 574.4 сая төгрөгийг санхүүжилтийг улсын төсвөөс, 68.1 сая төгрөгийн бараа материал, нийтдээ 642.5 сая төгрөгийн хөрөнгийг төлөвлөжээ.



**Бүлэг 2: Сонгуулийн хууль, холбогдох журмыг мөрдөн ажиллаж байгаа ч зарим төсвийг үр ашиг, арвилан хэмнэлттэйгээр зарцуулаагүй байна.**

**Сумдын сонгуулийн хороо нь батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулжээ.**

2.1 Аймгийн сонгуулийн хороонд СЕХ-оос ирсэн зөвлөмж, аргачлалын дагуу сумдын сонгуулийн хороонд 423.6 сая төгрөгийг хуваарилжээ. Сумдын сонгуулийн хороо нь аймгийн Сонгуулийн хорооноос өгсөн аргачлал, зөвлөмжийн дагуу зардлыг санхүүжүүлж авлага, өр төлбөр үүсгээгүйгээр ажиллажээ. Сумдад олгосон санхүүжилтийг хүснэгтээр харуулбал:

Сонгуулийн хорооны нэрс	Төлөвлөгөө /сая төг/	Гүйцэтгэл /сая төг/
Алтай сумын сонгуулийн хороо	20.4	20.4
Булган сумын сонгуулийн хороо	28.0	28.0
Буянт сумын сонгуулийн хороо	23.3	23.3
Дарви сумын сонгуулийн хороо	22.9	22.9
Дуут сумын сонгуулийн хороо	18.1	18.1
Дөргөн сумын сонгуулийн хороо	18.9	18.9
Зэрэг сумын сонгуулийн хороо	22.8	22.8
Жаргалант сумын сонгуулийн хороо	55.4	55.4
Манхан сумын сонгуулийн хороо	26.7	26.7
Мөнххайрхан сумын сонгуулийн хороо	19.5	19.5
Мөст сумын сонгуулийн хороо	23.4	23.4
Мянгад сумын сонгуулийн хороо	23.0	23.0
Үенч сумын сонгуулийн хороо	25.4	25.4
Ховд сумын сонгуулийн хороо	21.9	21.9
Цэцэг сумын сонгуулийн хороо	22.8	22.8
Чандмань сумын сонгуулийн хороо	26.1	26.1
Эрдэнэбүрэн сумын сонгуулийн хороо	23.4	23.4
<b>Нийт дүн</b>	<b>422.2</b>	<b>422.2</b>

Ховд сумын сонгуулийн хороо нь 0.6 сая төгрөгийн томилолтын зардал олгохдоо томилолтын хуудас дээр аймгийн сонгуулийн хорооны тамга тэмдэг дарж баталгаажаагүй байхад олгожээ.

**Аймгийн сонгуулийн хороо нь 5.3 сая төгрөгийг үр ашиггүй зарцуулжээ.**

2.2 Аймгийн сонгуулийн хороо нь 56.6 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлж 0.3 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Сургалтын зардлыг 0.3, унааны зардлыг 3.3 сая төгрөгөөр хэмнэж саналын хуудас тоолох төхөөрөмж авах, хүлээлгэн өгөх зардлыг 3.3 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна. Унааны зардлыг хэмнэсэн шалтгаан нь аймгийн сонгуулийн хороо нь саналын хуудас болон сургалтыг Ковид-19 цар тахлын улмаас олон хүний цугларалт үүсгэх боломжгүй болсонтой холбоотойгоор сумдад очиж зохион байгуулсантай холбоотой байна.

- Аймгийн сонгуулийн хороо нь сургалтын зардлаас 1.1 сая төгрөгийг Төсвийн тухай хуулийн 16.5.5<sup>1</sup> зөрчин сонгуулийн хорооны ажилчдад хоолны мөнгө гэж олгосон тул төлбөрийн акт бичлээ.

<sup>1</sup> Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах  
Аудитын код: ХОА-2020/02/ГА

- Шуудан холбооны зардал болон унааны зардлаас 0.4 сая төгрөгийн гүйлгээг давхардуулан гаргасан байгаа нь Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 16.2.5<sup>2</sup>, Төсвийн тухай хуулийн 6.4.8<sup>3</sup> дахь заалтуудтай нийцээгүй тул төлбөрийн акт бичлээ.
- Болзошгүй зардал, сургалтын зардлаас хоолны зардалд 2.5, хүнсний материалын зардалд 1.3 сая төгрөгийг гаргаж төсвийг үр ашиггүй зарцуулжээ.

**Аймгийн сонгуулийн хороо нь сумдын сонгуулийн хорооны тайланд нийт 3.1 сая төгрөгийн алдааг залруулсан нэгтгэсэн байна.**

**2.2** Аймгийн 17 сумдын сонгуулийн хороо нь сонгуулийн хорооны гишүүнээрээ нягтлан бодогчийн ажлыг хавсруулан гүйцэтгүүлжээ. Зарим сумдын сонгуулийн хорооны нягтлан бодогч нь сонгуулийн хорооны тайланг зөрүүтэй тайлагнасан байна. Аймгийн сонгуулийн хороо нь сумдын сонгуулийн хорооны тайланг хүлээн авч нэгтгэхдээ дээрх сумдын нийт 3.1 сая төгрөгийн алдааг залруулан нэгтгэжээ. Аймгийн сонгуулийн хорооны зардлын гүйцэтгэлийг харуулбал:

№	Зардлын нэр	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Тогтоол, протокол, бусад маягт хэвлүүлэх зардал	0.25	0.25	
2	Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хорооны сургалтын зардал	6.01	5.75	0.26
3	Мэдээлэл технологийн баг, даамлын сургалтын зардал	12.77	12.77	
4	Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хорооны бичиг хэргийн зардал	14.44	14.44	
5	Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хорооны шуудан зардал	17.20	17.20	
6	Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хорооны унааны зардал	53.20	49.90	
7	Санал авах байр, төрийн далбаа бэлтгэх зардал	20.02	20.02	
8	Саналын хуудас, санал тоолох төхөөрөмж авах, хүлээлгэн өгөх зардал	21.90	25.20	
9	МТБ-ийн мэдээ дамжуулах холбоо, унааны зардал	0.65	0.65	
10	Эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх зардал	3.19	3.19	
11	Сурталчилгааны зардал	5.00	5.00	
12	Саналын хуудас устгах зардал	0.46	0.46	
13	Томилолтын зардал	6.85	6.85	
14	Болзошгүй зардал	3.00	3.00	
15	Аймаг, нийслэл, сум, дүүрэг, хэсгийн хорооны гишүүдийн урамшуулал, хоолны зардал	270.74	270.74	
16	Мэдээлэл технологийн багийн гишүүн, даамлын урамшуулал, хоолны зардал	40.00	40.00	
17	Мэдээ дамжуулах унааны зардал	3.47	3.47	
<b>НИЙТ ДҮН</b>		<b>479.13</b>	<b>478.87</b>	<b>0</b>

Сургалтын зардлыг 0.3, унааны зардлыг 3.3 сая төгрөгөөр хэмнэж саналын хуудас тоолох төхөөрөмж авах, хүлээлгэн өгөх зардлыг 3.3 сая төгрөгөөр хэтрүүлэн

<sup>2</sup> сонгуулийн ерөнхий хорооноос хуваарилсан төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу захиран зарцуулах, зохих журмын дагуу харьяалах сонгуулийн хороодод хуваарилах, зарцуулалтад нь хяналт тавих

<sup>3</sup> төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх



зарцуулсан байна. Унааны зардлыг хэмнэсэн шалтгаан нь аймгийн сонгуулийн хороо нь саналын хуудас болон сургалтыг аймагт зохион байгуулахгүйгээр сумдад очиж зохион байгуулсантай холбоотой байна.

***Улсын бүртгэлийн хэлтэс сонгуулийн зардлыг холбогдох хууль, журмыг мөрдөж зарцуулсан ч зарим зардлыг үр ашиг, арвилан хэмнэлттэй зарцуулаагүй, санхүүгийн дотоод хяналт хангалтгүй байна***

**2.4** Улсын бүртгэлийн байгууллагын ажилтан, итгэмжлэгдсэн ажилтны болон гэрээт ажилтны мөнгөн урамшуулал, хоол унааны зардалд 55.6 сая, сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэхэд шаардагдах бичиг хэргийн зардалд 4.0 сая, сургалт зохион байгуулах болон түүнтэй холбогдон гарах бусад зардалд 14.9 сая, сонгогчийг бүртгэх, таних техник хэрэгслийг тээвэрлэх болон техник хэрэгслийн хэвийн ажиллагааг хангаж ажиллах шуурхай багийн зардалд 11.3 сая нийт 85.8 сая төгрөгийн батлагдсан төсвийг зориулалтын дагуу, холбогдох хууль журмыг баримтлан зарцуулсан ч дараах зөрчил дутагдал илэрлээ. Үүнд:

- Аймгийн төв, Жаргалант сумаас сургалтад хамрагдсан 26 ажилтан, албан хаагчид 2.6 сая төгрөгийн томилолт илүү тооцож олгосон
- Бичгийн цаас, принтерийн хорыг төсөвт тусгагдсан дүнгээс 3.2 сая төгрөгөөр хэтрүүлэн худалдан авч, мөн 0,3 сая төгрөгөөр авто машины дугуй худалдан авч байгууллагын үйл ажиллагаанд зарцуулсан байна.
- Сонгуулийн жилд шинээр итгэмжлэгдсэн төлөөлөгч сургаж дадлагажуулан ажиллуулах боломж байхгүйгээс улсын бүртгэлийн ажилтнууд итгэмжлэгдсэн ажилтны ажлыг давхар гүйцэтгэн ажилласан байна.
- Аудитаар санхүүгийн баримт материалын анхан шатны бүрдүүлэлт хангалтгүй байсан тул 46.3 сая төгрөгийн алдааг залрууллаа.

***Онцгой байдлын газар хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналт, анхан шатны баримтын бүрдлийг сайжруулах шаардлагатай байна.***

**2.5** Засгийн газрын 2020 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн 199 дүгээр тогтоолын дагуу Онцгой байдлын ерөнхий газраас аймгийн Онцгой байдлын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд 3.3 сая төгрөгийг Улсын Их Хурлын сонгуулийн санал хураах байранд томилогдон ажиллах алба хаагчдын томилолтын зардалд зарцуулахаар хуваарилжээ.

Дээрх 3.3 сая төгрөгийг 2020 оны 7 дугаар сарын 21-ны өдөр 17 сумдын Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд хуваарилан шилжүүлэхдээ санхүүгийн анхан шатны баримтын бүрдлийг хангаагүй гүйлгээ хийсэн. Нөгөө талаас ажилтан, албан хаагчдын томилолт нөхөн олговрыг байгууллагын дотоод журамд заасан хугацаанд тооцож олгохгүй байгаа зөрчил байна.

***Засгийн газрын нөөц хөрөнгөөс санхүүжүүлсэн зардлыг зориулалтын дагуу зарцуулсан эсэхийг нотлох санхүүгийн баримт хангалттай түвшинд бүрдээгүй байна.***

**2.6** Засгийн газрын 2020 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн 199 дүгээр тогтоолын дагуу Засгийн газрын нөөц сангаас УИХ-ын ээлжит сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны явцад коронавируст халдвар, Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх журмын хэрэгжилтийг хангах зорилгоор сонгогчид болон, сонгуулийн ажилтны тоогоор 7 нэр төрлийн 121474 тоо ширхэг бүхий 68,1 сая төгрөгийн амны хаалт, бээлий, гар ариутгагч, хлорын шохой зэрэг бараа материалыг 2020 оны 06 дугаар сарын 11-ны өдөр хүлээн авч данс бүртгэлд тусгасан байна.

Аудитаар бараа материалын зарцуулалтыг хянахад Алтай, Үенч, Жаргалант сумдын сонгуулийн хороо бараа материалын тайланг гаргаж, ЗДТГ-т хүлээлгэн өгсөн, бусад сумууд бараа материалыг хэрхэн зарцуулсан талаарх тайлан тооцоогүй ирүүлээгүй байна.

Эндээс сонгуулийн санал дунджаар 79% ийн ирцтэй тоологдсоноос хамаарч дээрх бараа материалын зарцуулалт мөн адил 79%-ийн гүйцэтгэлтэй зарцуулагдсанаар 12.7 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байгаа эсэхийг тооцоо нийлж, буцаан төвлөрүүлээгүй, бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

***Аймгийн сонгуулийн хороо нь сумдын сонгуулийн хороодын хөрөнгийн зарцуулалтад хяналт тавин ажилласан ч бараа материалын зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах шаардлагатай.***

**2.3** Аймгийн сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүд Ховд аймгийн 17 сумдаар ажиллаж сонгууль явуулахтай холбоотой хөрөнгийн зарцуулалт болон санал авах байранд ажиллах сертификат авсан төрийн жинхэнэ албан хаагчдыг хамарсан сургалт, арга зүйн зөвлөмж, зөвлөгөөг өгч ажилласан байна.

Аймгийн сонгуулийн хороо нь 3 баг болж 17 сумдын 91 хэсгийн хороодод очиж хяналт шалгалтыг хийж ажиллажээ. Тус шалгалтаар жолоочийн тооцоо бодуулаагүй, санал авах байрны тохижилт дутуу хийгдсэн, хэсгийн хорооны гишүүд хороон дээрээ байгаагүй зэрэг дутагдал илэрснийг газар дээр нь засаж залруулан ажиллажээ.

Гэвч аудитаар сумдын сонгуулийн хорооноос ирүүлсэн тайланд онцгой байдлын газраас олгосон бараа материалын тайланг нэгтгэж гаргаагүй байна.

Аймгийн сонгуулийн хорооны нягтлан бодогч нь сумдын сонгуулийн хорооны тайланг хүлээн авахдаа зөрүүтэй илэрхийлсэн алдааг хянаж залруулан авч дүнг үнэн зөв нэгтгэн гаргасан байна.

**Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:**

***Улсын төсвөөс олгох санхүүжилтийг хэрэгцээний дагуу төлөвлөн СЕХ-оос ирүүлсэн аргачлалын дагуу хуваарилсан ч урамшуулалт цалингийн НДШ-ын зардал, улсын бүртгэлийн газарт төлөвлөн олгосон зарим зардал оновчтой төлөвлөгдөөгүй байна.***

- ✚ **Сонгуулийн хууль, холбогдох журмыг мөрдөн ажиллаж байгаа ч зарим төсвийг үр ашиг, арвилан хэмнэлттэйгээр зарцуулаагүй байна.**

Аудитаар нийт 33.3 сая төгрөгийн төлбөр зөрчил илэрснээс 2 актаар 7.7 сая төгрөгийн алдаа зөрчилд төлбөрийн акт бичиж 25.6 сая төгрөгийн 5 зөвлөмж бичигдлээ.

Аудитын дүнд илэрсэн зөрчилд үндэслэн дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна.

### **ЗӨВЛӨМЖ:**

#### **Аймгийн онцгой комиссын дарга Б.Дүгэржав-д**

- ✚ Аймгийн ОБГ-аас олгосон халдваргүйжүүлэлтийн бараа материалын зарцуулалтад тавих хяналтыг сайжруулан ажиллах

#### **Аймгийн сонгуулийн хорооны дарга Б.Сандагсүрэнд:**

- ✚ Батлагдсан төсвийг үр ашигтай, үр нөлөөтэй, арвилан хэмнэлттэй зарцуулж батлагдаагүй хоолны зардлыг санхүүжүүлдэг байдлыг зогсоох
- ✚ Батлагдсан төсвийг СЕХ-оос ирүүлсэн аргачлалын дагуу зарцуулж хэмнэгдсэн зардлыг бусад зардалд зарцуулахгүй байх
- ✚ ОБГ-аас сумдын ЗДТГ-ын нэмэлт дансанд шилжүүлж олгогдоогүй байгаа 2.9 сая төгрөгийн томилолтын зардлыг бүрэн олгох

#### **Улсын бүртгэлийн хэлтсийн дарга С.Хоролсүрэнд:**

- ✚ Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай, арвилан хэмнэлттэй зарцуулж, санхүү бүртгэлээр тавих дотоод хяналтыг сайжруулан ажиллах
- ✚ Итгэмжлэгдсэн албан хаагчдыг нөөцөөс бүрдүүлэн төлөвлөлтийн дагуу ажиллуулж, урамшуулалт цалинг батлагдсан төсвийн дагуу олгох

Аудитаар өгөгдсөн зөвлөмжийн биелэлтийг 2020 оны 09 дүгээр сарын 30-ний дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт албан бичгээр ирүүлнэ үү.

#### **ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦСАН:**

**ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:**

**Х.БОЛДБААТАР**

#### **ТАЙЛАН ХЯНАСАН:**

**АУДИТЫН МЕНЕЖЕР:**

**А.ЦЭЦЭГСҮРЭН**

#### **ТАЙЛАН БИЧСЭН:**

**АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР**

**Д.МӨНХТУЛГА  
Б.ДОЛЖИНЖАВ**

